



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9 дэх заалт, 79.1 дэх заалт, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 160 дугаар тогтоол, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.2 дах хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2.в дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Лочингалсангийн Батжаргалыг өөрийнх нь хүсэлтийн дагуу үүрэгт ажлаас нь 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс чөлөөлж, түүнтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.

2. Гүйцэтгэх захирал Л.Батжаргалтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг олгохыг Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхтуяа/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ